

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2021.12.23

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийн шууд захирагчийн 2021 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.7-д заасны дагуу 2021 оны жилийн эцсийн Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийн шууд захирагчийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны ”Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв.

Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд:

- “үр дүнтэй” 100 хувь;
- “тодорхой үр дүнд хүрсэн” 70 – 99 хүртэл хувь;
- “эрчимжүүлэх шаардлагатай” 31 – 69 хүртэл хувь;
- “үр дүнгүй” 0- 30 хүртэл хувь үнэлгээг гаргалаа.

Гурав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийн үнэлгээний задаргаа /хүснэгт 1/

№	Дэс дугаар	Арга хэмжээний	Гүйцэтгэлийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1.Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх (эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах) нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох.			
Зорилт-1.1 Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.			75.7%
1.	1.1.1	Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх.	50%
	1.1.2	Биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн бааз, платформ бий болгож хэрэгжүүлнэ.	100%
	1.1.3	Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгоно.	100%
	1.1.4	Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	30%
	1.1.5	Иргэд эрүүл, аюулгүй орчинд, өөрийн бие бялдарт тохирсон арга зүйн дагуу спортоор хичээллэх нөхцөлийг спортын сургалт-дасгалжуулалт, орчин, хэрэглэл материалын стандарт, түүнийг хэрэгжүүлэх спортын сургалтын жишиг хөтөлбөрөөр бүрдүүлэх, стандарт, хөтөлбөрийг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	50%
	1.1.6	Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлнэ.	100%
	1.1.7	Биеийн тамирын арга зүйчд мэргэжлийн зэрэг олгох, мэргэшүүлэх давтан сургалтыг зохион байгуулна.	100%
Зорилт-1.2 Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина.			57.5%
2.	1.2.1	Спортын төв ордон барих ажлыг эхлүүлнэ.	30%
	1.2.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборыг ашиглалтад оруулна.	70%
	1.2.3	Налайх, Баянзүрх, Баянгол дүүргийн иргэдэд үйлчлэх усан бассейн бүхий спортын цогцолборын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулна.	100%
	1.2.4	Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.	30%
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх.			


Зорилт-2.1. Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.		45%	
3.	2.1.1	Үндэсний уламжлалт спортын төв байгуулах, үндэсний багтай болно.	30%
	2.1.2	Улсын хэмжээнд иргэдийн дунд нийтийн спортын төрөлжсөн наадмыг 2-4 жил тутамд зохион байгуулна.	70%
	2.1.3	Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд сурталчлан таниулж, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулна.	30%
	2.1.4	Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд сурталчлан таниулж, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулна.	50%
Зорилт-2.2 Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах.		89%	
4.	2.2.1	Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад мөнгөн шагнал олгох, олимпын наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчдад сар бүр урамшуулал олгоно.	100%
	2.2.2	Сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулна.	100%
	2.2.3	Үндэсний шигшээ багийн спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана.	100%
	2.2.4	Хүүхэд, залуучуудын спортын авьяасыг илрүүлж шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх хүрээнд үндэсний хэмжээнд спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнийг жил тутам зохион явуулах, зохион байгуулалтыг оновчтой болгоно.	70%
	2.2.5	Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээний хийх болон өсвөр үеийн шигшээ багт хүрч ажиллах дэд бүтцийн сайжруулна.	70%
	2.2.6	Спортын холбоодын урт хугацааны бодлого төлөвлөлтийг боловсруулна.	100%
	2.2.7	Өвөл, багийн, болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны ба шинэ тутам хөгжиж буй спортын төрлүүдээр чадамжийг дээшлүүлэх сургалт зохион байгуулна.	50%
	2.2.8	Үндэсний шигшээ багийг бүрдүүлж буй спортын холбоодтой хамтран гадаадын өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг урьж ажиллуулна.	100%
	2.2.9	Үндэсний шигшээ багт сонгогдсон спортын холбоодтой гэрээ байгуулж, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгийг холбогдох хууль, журмын дагуу үзүүлэх.	100%
	2.2.10	Үндэсний шигшээ багуудын 2021 онд оролцох “Токио-2020” олимп, паралимпийн наадамд оролцох эрх авах, оноо цуглуулах тив, дэлхий, олон улсын тэмцээн, гадаад болон дотоодын бэлтгэл цугларалтын нэгдсэн календарчилсан төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний дагуу оролцох	100%
Стратегийн зорилго 3. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах			
Зорилт-3.1. Салбарын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилтэд тайлагналтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах		100%	
5.	3.1.1	Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоол, шийдвэр, бодлого зохицуулалтын хэрэгжилтийн чанар үр нөлөөг дээшлүүлэх, шийдвэрийн мэдээллийн сан бүрдүүлж, төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан мэдээг нэгтгэнэ.	100%

	3.1.2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нөхцөлийг хангах, жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлнэ.	100%
Зорилт-3.2.Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх.			80%
6.	3.2.1	Допингийн эсрэг үндэсний дүрмийн төсөл боловсруулна.	70%
	3.2.2	Улсын хэмжээний тэмцээн, наадмыг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын төсөл боловсруулна.	70%
	3.2.3	Байгууллагын стратегийн төлөвлөгөөний төслийг боловсруулан батлуулна.	100%
	3.2.4	Биеийн тамир, спортын салбарын статистикийн мэдээний дүнг нэгтгэх, статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.	100%
	3.2.5	Галт зэвсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэгт заасны дагуу галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд санал дүгнэлт гаргана.	30%
	3.2.6	Галт зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан тирд тавих шаардлага, 11 дүгээр зүйлийн 11.9 дахь хэсэгт заасан галт зэвсэг эзэмших, хадгалах журмыг шинэчлэн саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ.	100%
	3.2.7	Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам батална.	90%
Зорилт-3.3 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах.			100%
7.	3.3.1	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, чадавхыг дээшлүүлэх болон албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.	100%
	3.3.2	Мэдээллийн ил тод байдал, цахим үйл ажиллагааг хангах, харьяа байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг зохион байгуулна.	100%
	3.3.3	Салбарын болон байгууллагын хүний нөөцийн сургалтад хамруулах, харилцан хамтын үйл ажиллагааг зохион байгуулна.	100%
	3.4.4	Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын төрийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, бодлого төлөвлөлтийг сайжруулна.	100%
Зорилт-3.4 Салбарын бодлогын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах			100%
8.	3.4.1	Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.	100%
Зорилт 3.5 Төвлөрүүлэн захирагчийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, зохицуулалтаар хангах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах.			100%
9.	3.5.1	Биеийн тамир, спортын салбарын урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулна.	100%
	3.5.2	Байгууллагын орлого, санхүүжилтийн хэрэгцээг бодитой тодорхойлох, төсвийн гүйцэтгэлийг хангуулах, санхүүгийн үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулна.	100%
	3.5.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн багцын батлагдсан төсвийн хүрээнд харьяа байгууллагуудыг санхүүжүүлэх, хяналт тавина.	100%


	3.5.4	Улсын төсвийн хөрөнгө оруул алтаар Биеийн тамир, спортын салбар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг хянаж санхүүжүүлнэ.	100%
	3.5.5	Төсвийн ил тод байдлыг хангана.	100%
Зорилт -3.6 Биеийн тамир, спортын чиглэлээр гадаад улсын Засгийн газар болон бусад ижил төстэй байгууллагуудтай хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, хэрэгжилтийг хангах.			90%
10.	3.6.1	Биеийн тамир, спортын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Биеийн тамир, спортын улсын хороо болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Залуучууд, спортын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг байгуулна.	90%
Зорилт-3.7 Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж, дүгнэлтээр хангах, хяналт тавих.			100%
10.	3.7.1	Монгол Улсын засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх нийтлэг журмыг шинэчлэн батлах ажлыг зохион байгуулна.	100%
	3.7.2	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээг 2021 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /ЗГ-ын 335 -р тогтоол/	100%
Зорилт-3.8 Биеийн тамир, спортын салбарын хэмжээнд дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэн сайжруулах			100%
11.	3.8.1	Эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөө, дүрэм боловсруулж хэлэлцүүлнэ.	100%
	3.8.2.	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад төлөвлөгөөт дотоод аудит хийх, дүгнэлт зөвлөмжөөр хангана.	100%

Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийн зорилт, арга хэмжээг дараах графикаар үзүүлэв.

Арга хэмжээ график-1 82.8%



Зорилтын дундаж график-12 86.4%



Гурав. Дүгнэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтэд 3 зорилгын хүрээнд 12 зорилт 49 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ зорилтын дундаж үнэлгээгээр 86.4 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээгээр 1.1 дүгээр зорилтын 1.1.1 дэх арга хэмжээ, 1.1.4 дэх арга хэмжээ, 2.1 дугаар зорилтын 2.1.1 дэх арга хэмжээ, 2.2 дугаар зорилтын 2.2.7 дэх арга хэмжээ тус бүр “Ковид-19” цар тахлын улмаас хэрэгжилт удааширсан байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2021 оны төлөвлөгөөнд зорилт 1.1 дүгээр зорилтын 1.1.3 дэх арга хэмжээ, 2.1 дүгээр зорилтын 2.1.3 дэх арга хэмжээ, 2.1.4 дэх арга хэмжээ тус бүр хариуцах нэгж байгаа боловч яг ямар ажил хариуцах нь тодорхойгүй.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хугацааны хувьд задалж үе шат, ажил бүрээр нь тодорхойлоогүй байгаа нь ажлын явц, хүрсэн түвшин, биелэх боломж, шаардагдах хугацаа зэргийн явцыг үр дүнтэй хянах, үнэлэх, дахин төлөвлөх, үйл ажиллагааг эрчимжүүлэхэд хүндрэл учруулж улмаар эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж дүгнэж байна.

Дөрөв. Зөвлөмж

1.1.1. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх.

1.1.4. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүр цар талын улмаас хэрэгжилт удааширсан тул 2022

оны төлөвлөгөөнд дахин төлөвлөж эрчимжүүлэх шаардлагатайг Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтэс.

1.1.5. Иргэд эрүүл, аюулгүй орчинд, өөрийн бие бялдарт тохирсон арга зүйн дагуу спортоор хичээллэх нөхцөлийг спортын сургалт-дасгалжуулалт, орчин, хэрэглэл материалын стандарт, түүнийг хэрэгжүүлэх спортын сургалтын жишиг хөтөлбөрөөр бүрдүүлэх, стандарт, хөтөлбөрийг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх ажлыг 2022 оны төлөвлөгөөнд хариуцах албан хаагчийг томилж эзэнчлүүлэх шаардлагатайг Спортын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтэс.

1.2.1. Спортын төв ордон барих ажлыг эхлүүлэх ажлыг 2022 оны төлөвлөгөөнд тусгаж эрчимжүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар;

1.2.4. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг шинэчлэн сайжруулах ажлыг 2022 оны төлөвлөгөөнд төлөвлөж эрчимжүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар;

2.1.1. Үндэсний уламжлалт спортын төв байгуулах, үндэсний багтай болох ажлын даалгавар боловсруулах ажлыг Бодлого, төлөвлөлтийн газар;

2.1.3. Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгох, үндэсний спортын холбоодын хөгжлийг дэмжинэ,

2.1.4. Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд сурталчлан таниулж, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулна,

2.2.7. Өвөл, багийн, болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны ба шинэ тутам хөгжиж буй спортын төрлүүдээр чадамжийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах арга хэмжээ хариуцах нэгж нь тодорхой боловч, хийх ажил нь тодорхой биш тусгасан бөгөөд ажил бүрээр нь нарийвчлалтай тусгах, нийт хугацааг задалж үе шаттай төлөвлөгөөнд нарийвчлалтай зааж анхаарч ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар.

2.2.5. Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээ хийх болон өсвөр үеийн шигшээ багт хүрч ажиллах дэд бүтцийг сайжруулж ажиллахыг Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэст.

3.2.5. Галт зэвсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэгт заасны дагуу галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд санал дүгнэлт гаргахад хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй уялдаатай байх. 2022 оны төлөвлөгөөнд тусгахгүй байхыг Бодлого, төлөвлөлтийн газар.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Байгууллагын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг тус бүр байгууллагын гүйцэтгэлийн 2022 оны төлөвлөгөөтэй уялдуулах, хариуцах нэгж нь тодорхой илүү нарийвчлалтай, ойлгомжтой үр дүнд сайнаар нөлөөлөхүйц төлөвлөхийг анхаарч ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газарт тус тус зөвлөмж болгож байна.